

# Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавих, дүгнэхэд анхаарах асуудал.

Дорнод аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын  
газрын уул уурхай хариуцсан мэргэжлтэн Х.Батхуяг.

Чойбалсан хот


2021-01-20

# АГУУЛГА

- \* Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавих.
- \* Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэх.
- \* Ажлын хэсгийн гишүүдийн үүрэг, хариуцлага.


# Дорнод аймаг дахь ашигт малтмалын өнөөгийн байдал.


Дорнод аймгийн хэмжээнд олгогдоод байгаа ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн тоо.



# Дорнод аймаг дахь газрын тосны өнөөгийн байдал.

Дорнод аймгийн хэмжээнд газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээг 5 аж ахуйн нэгж, Монгол улсын Засгийн газартай байгуулж, нийт 6 талбайд эрэл, хайгуул, олборлолт явуулахаар тусгай зөвшөөрөл эзэмшиж байна.





# Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах.

\* Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах.

\* Төслийн хэрэгжүүлэгч нь жил бүрийн 12 дугаар сард багтаан дараа жилд хэрэгжүүлэх БОМТ-г боловсруулж, ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагад хүргүүлнэ.

/уг журмын 2.1, 2.5/

\* Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, нэмэлт тодотголыг үнэлгээний мэргэжлийн зөвлөл баталснаас хойш 1 сарын дотор тухайн жилийн БОМТ-г боловсруулж, ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагад хүргүүлнэ.

/уг журмын 2.2/

# Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлах.

- \* Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлах.
  - \* Ашигт малтмалын хайгуулын төслийн хувьд тухайн сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч хянаж, сумын Засаг дарга батална. /уг журмын 3.5/
  - \* Бусад төслийн хувьд ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага хянаж, батална. /БОАЖГазар/ /уг журмын 3.4/
  - \* Улиралын чанартай үйл ажиллагаа явуулдаг /хайгуул, дэд бүтцийн барилга байгууламж барих/ төслийн хувьд тухайн оны төлөвлөлттэй уялдуулан эхний улиралд багтаан хянаж, батална. /уг журмын 3.6/

# Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих.

- \* Батлагдсан тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг төсөл хэрэгжүүлэгч төслийн талбайд байнга байлгана.
- \* Ашигт малтмалын тухай хуулийн 35, 38, 39 дүгээр зүйл.
- \* Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай 25, 27, 28 дугаар зүйл.

# Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих.

- \* Аймгийн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн байгууллагаас зөвшөөрөл авалгүйгээр уул уурхайн хайгуул, ашиглалт явуулахыг хориглох.
- \* Ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагын хянаж, баталсан тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төслийн үйл ажиллагааг эхлүүлэх, үргэлжлүүлэхийг зөвшөөрсөн баримт бичиг болно.
  - \* Ашигт малтмалын тухай хуулийн 37 дугаар зүйл.
  - \* Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай 26 дугаар зүйл.
  - \* Уг журмын 1.4 дэх заалт. /БОАЖС-ын 2019 оны А/618/

## \* Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд хяналт тавих.

- Сөрөг нөлөөллийг бууруулах

  - Хөрс, ургамал, ан амьтан, агаар, тэмдэг тэмдэглэгээ

- Нөхөн сэргээлт /техник болон биологи/

  - Техникийн нөхөн сэргээлт хийсэн газарт биологийн нөхөн сэргээлт хийнэ.

  - Тариалах хугацаа 5-6 сард багтаан тариалах ёстой.

- Дүйцүүлэн хамгаалал

  - Ашиглалт, олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа төсөлд хамаарна.

# Уул уурхайн салбарын байгаль орчны хамгаалал.

## -Нүүлгэн шилжүүлэлт.

- \* Уул уурхайн төслийн хайгуулын үе шатанд бүрэн шийдвэрлэнэ.
- \* Бусад төслийн хувьд байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийлгэхээс өмнө шийдвэрлэсэн байна.
- \* -Түүх, соёлын өвийг хамгаалах.
  - \* Төслийн үйл ажиллагааны явцад илэрвэл, сумын Засаг даргад яаралтай мэдэгдэж, үйл ажиллагааг зогсоон, хамгаалалтад авна.
- \* -Осол, эрсдэлийн менежмент
  - \* Химийн бодис, авар осол, байгалийн гамшигийн үед хэрэгжүүлэх арга хэмжээ.

# Уул уурхайн салбарын байгаль орчны хамгаалал.

## -Хог хаягдлын менежмент

- \* Хээрийн анги кэмп бүр хог хаягдлын түр цэгийг газар ухаж хийхийг хориглоно.
- \* Сумтай хог хаягдлын гэрээ байгуулна.

## -Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.

- \* Төслийн орчимд тодорхой нэг цэгээс давтамжтайгаар хөрс, ус, агаарт шинжилгээ хийнэ.
- \* Хөндлөнгийн хяналтаар байнга оролцох.

## -Удирдлага зохион байгуулалт


-Аймаг, сум орон нутгийн төрийн захиргааны байгууллагын шаардлагаар хийсэн ажил, нөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах

# Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэх.

- \* Аймгийн Засаг даргын 2020 оны А/500 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг.
  - \* Төсөл хэрэгжүүлэгч байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайланг хүргүүлэх хугацааг анхаарах.
  - \* Тайлангийг бичвэр, бүрдэл хэсгийг хянах. /буцаах/
  - \* Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ бүрээр хянаж, үнэлнэ.
  - \* Үнэлгээг хараат бус байдлаар бие дааж өгнө.
  - \* Үнэлгээний хуудсанд гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулна.
  - \* Ашиг сонирхлын зөрчилтэй эсэх талаарх маягтыг үнэн зөв бөглөнө.
  - \* Үнэлгээг нэгтгэсэн хуудсанд гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулна.


# Уул уурхайн салбарын байгаль орчны хамгаалал.

**Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний  
дүгнэлт гаргасан байдал.**



# Уул уурхайн нөлөөгөөр эвдрэлд орсон газрын тооллого. /2018/

**Талбай. /1447 га/**





АНХААРАЛ ХАНДУУЛСАН ТА  
БҮХЭНД БАЯРЛАЛАА.